



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2024 оны 08 сарын 29 өдөр

Дугаар А/20

Мандалговь

Байгууллагын хүүхэд хамгааллын
бодлого батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Хөдөлмөрийн тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.3 дахь хэсэг, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын садын "Хүүхэд хамгааллын бодлогыг хэрэгжүүлэх үлгэрчилсэн заавар батлах тухай" 2022 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн А/110 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Гэр бүл, нийгмийн хүрээнд хүүхдийн аюулгүй байдлыг хангах, хүүхдэд ээлтэй орчин бүрдүүлэх, ажилтан албан хаагчдын ажил амьдралын тэнцвэрт байдлыг хангахад чиглэсэн "Хүүхэд хамгааллын бодлого"-ыг нэгдүгээр, "Хүүхэд хамгааллын зөрчлийн талаар мэдээлэх хуудас"-ыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Хүүхэд хамгааллын бодлогыг байгууллагын үйл ажиллагааны онцлог, дотоод хэм хэмжээний хүрээнд мөрдөж ажиллахыг албан хаагчдад үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтийг хангаж, мэргэжил, арга зүйн удирдлагаар ханган ажиллахыг байгууллагын эцэг, эхийн зөвлөлийн даргад даалгасугай

ДАРГА



С.ХУЛАН

482412063

Орон нутгийн өмчийн газрын даргын
2024 оны 08 дугаар сарын 29-ны өдрийн А/АО
дугаар тушаалын нэгдүгээр хавсралт

**ДУНДГОВЬ АЙМГИЙН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ГАЗРЫН
ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН БОДЛОГО**

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Бүх шатны байгууллага нь Хүүхдийн төлөө үндэсний зөвлөлийн 2018 оны 03 дугаар тогтоолоор баталсан Хүүхэд хамгааллын жишиг бодлого, Эцэг эхийн зөвлөл байгуулах зөвлөмж, Хөдөлмөрийн тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.3 дахь хэсэгт заасны дагуу ажилтны ажил, амралтын цагийг зохицуулах, амьдралын тэнцвэрийг хангахад дэмжлэг үзүүлэх, хөдөлмөрийн дотоод журамд тусгах замаар ажилтны хүүхдэд ээлтэй, хүүхэд хамгааллын бодлого хэрэгжүүлнэ.

1.2. Ажилтан, албан хаагчдаараа дамжуулан гэр бүл, нийгмийн хүрээнд хүүхдийн аюулгүй байдлыг хангах, хүүхдийг эрсдэлээс урьдчилан сэргийлэх, хамгаалах, үүрэг хариуцлагаа биелүүлэхэд чиглэсэн сургалт нөлөөллийн ажил зохион байгуулж, салбарын хэмжээнд байгууллагын нөөц, байгууллагын онцлогт нийцүүлэн хүүхдэд ээлтэй орчин бүрдүүлж ажиллана.

Хоёр. Үндсэн зарчмууд

2.1. Хүүхдийн эрх, язгуур эрх ашиг, тэдний аюулгүй байдлыг нэн тэргүүнд тавьж, хүүхдийн эрхийг хүлээн зөвшөөрч, хүндэтгэн үзнэ.

2.2. Хүүхдийн эсрэг хүчирхийллийн аливаа хэлбэрийг хүлээн зөвшөөрөхгүй.

2.3. Аливаа үйл ажиллагаанд хүүхэд, гэр бүлийн хүчирхийлэл, үл хайхрах байдал, осол гэмтэлд өртүүлж болзошгүй аливаа эрсдэлээс урьдчилан сэргийлэх

Гурав. Хамрах хүрээ

3.1. Энэхүү баримт бичиг нь үндсэн болон гэрээт ажилтан, албан хаагч, ажилчин, сайн дурын ажилтан, дадлагажигч ажилтан, оюутан, зочид, судлаач, хамтран ажиллах байгууллагын ажилтнуудад хамаарна.

Дөрөв. Хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл

4.1. Байгууллага, ажил олгогч нь ажилтны ажил, амралтын цагийг зохицуулах, хөдөлмөрийн харилцааны уян хатан нөхцөл хэрэглэх зэргээр ажилтны ажил, амьдралын тэнцвэрийг хангах.

4.2. Цэцэрлэгийн болон бага ангийн хүүхэдтэй ажилтан, жирэмсэн, хөхүүл хүүхэдтэй эх, хөгжлийн бэрхшээлтэй болон байнгын асаргаа, сувилгаа шаардлагатай өрхийн гишүүнтэй ажилтан, өрх толгойлсон эцэг, эхийн ажиллах нөхцөлийг уян хатан болгож хамтын гэрээ, хөдөлмөрийн дотоод хэм хэмжээнд тусгуулж, мөрдүүлнэ. Үүнд:

4.2.1. богиносгосон цагаар ажиллах;

4.2.2. цахимаар ажиллах;

4.2.3. хүүхдээ цэцэрлэг, сургуульд хүргэж өгөх, авах боломжоор хангах;

4.2.4. шөнийн ээлжийн ажилд аль болох хуваарилахгүй байх;

4.2.5. цалингийн нэмэлт, урамшуулал дэмжлэг үзүүлэх;

4.2.6. бусад дэмжлэгт хамруулах.

4.3 Хүүхдэд ээлтэй байгууллагын шалгуурыг салбарын хэмжээнд мөрддөг хууль тогтоомж болон Хүүхдийн эрхийн тухай, Хүүхэд хамгааллын тухай, Хөдөлмөрийн тухай хууль тогтоомжтой нийцүүлэн боловсруулах.

4.4. Хүүхдийн төлөө үндэсний зөвлөлийн 2018 оны 03 дугаар тогтоолоор батлагдсан "Хүүхэд хамгааллын бодлогын жишиг баримт бичиг", "Байгууллагад эцэг эхийн зөвлөл байгуулах зөвлөмж"-ийн дагуу байгууллага ажилтнуудын гэр бүл, хүүхдэд чиглэсэн үйл ажиллагааг байгууллагын нөөц, хэрэгцээнд түшиглэн зохион байгуулах "Эцэг эхийн зөвлөл" /цаашид Зөвлөл гэх/-ийг байгуулах. Үүнд:

4.4.1. Зөвлөлийн дарга төлөвлөгөөг 1 жилийн хугацаатайгаар гарган хамт олноор хэлэлцүүлж, батлах бөгөөд биелэлтийг байгууллагын удирдлага, нийт хамт олонд тайлагнах;

4.4.2. Байгууллага хүүхэд хамгааллын бодлогын хэрэгжилтийн үнэлгээ хийж үр дүнд үндэслэн сайжруулж, мөрдүүлэх;

4.4.3. Байгууллагын мэдээллийн самбар цахим хуудаст байршуулж, сурталчлан таниулах;

4.4.4. Байгууллагын ажилтан, албан хаагчийн гэр бүл, хүүхдийн нөхцөл байдлын судалгаа хийж, хэрэгцээнд суурилсан сургалт, бодит дэмжлэг үзүүлэх, мэргэжлийн байгууллагын үйлчилгээнд холбон зуучлах.

4.5. Албан хаагчдадаа зориулж сургалт нөлөөллийн арга хэмжээ авч хэрэгжүүлэх.

4.5.1 Ажилтан, албан хаагчийн хүүхдийн сурч боловсрох, хөгжил, хамгаалыг дэмжих, эрүүл аюулгүй орчинг бүрдүүлэх, хүүхдэд ээлтэй байгууллага хамт олон болох санаачилгыг өрнүүлж, байгууллагын удирдлагатай хамтран ажиллах;

4.5.2. Мэргэжлийн байгууллагуудтай хамтран ажиллаж, ажилтан, албан хаагч, тэдний гэр бүл, хүүхдэд зориулсан соён гэгээрүүлэх, хөгжүүлэх, чадавжуулах сургалт, сэтгэл зүйн зөвлөгөөнд хамруулах.

4.6. Байгууллага өөрийн боломж, ажилтнуудын хэрэгцээ шаардлагад нийцсэн санал санаачилгыг өрнүүлж байгууллагын нөөцөд тулгуурлан хүүхдэд ээлтэй орчин бүрдүүлнэ. Тухайлбал:

4.6.1 Хүүхдийн хөгжих, эрүүл аюулгүй, хараа хяналттай байхад үргэлж анхаарч, байгууллагын дэргэдэх цэцэрлэг, өдөр өнжүүлэх төв, хүүхдийн өрөө, ажилтны амрах өрөө байгуулах;

4.6.2. Байгууллагын гадаад, дотоод орчны эрсдэлийн үнэлгээ хийх, илэрсэн эрсдэлийг арилгах арга хэмжээг байгууллагын хэмжээнд зохион байгуулах;

4.6.3. Байгууллагын үйлдвэрлэл, үйлчилгээ, үйл ажиллагаа нь хүүхдэд хор хөнөөл учруулж болзошгүй эрсдэл байгаа эсэхэд тогтмол үнэлгээ хийж, эрсдэлийг бууруулах, арилгах төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлэх

Тав. Ажилтнуудын ёс зүйн дүрэм

5.1. Байгууллагын удирдлага, ажилтан, албан хаагч бүр ажлын байр, гэр бүл, нийгмийн бүхий л орчинд зохисгүй зан үйл гаргахгүй байхад анхаарч, хүүхэд хамгааллын ёс зүйн хэм хэмжээг дагаж мөрдөнө.

Ажилтан		Байгууллага
Ёс зүйн дүрэмд заавал тусган	<ul style="list-style-type: none"> Хүүхдийг цохих, зодох, тусгаарлах зэргээр бие махбодын хүчирхийлэл үйлдэх Хүүхдийг гутаах, ичээх, доромжлох, дорд үзэх, нэр 	<ul style="list-style-type: none"> Байгууллагын хүүхэд хамгааллын бодлогыг зөрчиж байгаа нь мэдэгдсэн, сэжиглэгдсэн боловч мэдээгүй мэт өнгөрөөх, нуун дарагдуулах

хориглох зүйл	<p>хоч өгөх, сэтгэл зүйн дарамт учруулах зэргээр сэтгэл санааны хүчирхийлэл үйлдэх</p> <ul style="list-style-type: none"> • Хүүхэд, гэр бүлийн эсрэг бүх төрлийн хүчирхийл үйлдэх • Бусдыг садар самуунд уруу татсан тоглоом тоглох, шалиг үг ярих • Хүүхдийн дэргэд хараал хэлэх, бүдүүлэг үг хэрэглэх • Хүүхдийг ялгаварлан харилцах • Хүүхэд хүчирхийлэлд өртсөн, аюултай нөхцөл байдалд орсон тохиолдолд мэдээлэхгүй орхих • Зохисгүй хувцаслах, бэлгийн дур сонирхол төрүүлэхүйц байдал гаргах • Чанарын баталгаагүй, муудсан, хориглосон, чихэрлэг хоол хүнсээр хангах • Хүүхдийн зураг, дүрс, мэдээллийг зөвшөөрөлгүй хувийн фейсбүүк хуудас ба бусад хувийн нийгмийн сүлжээн дээр тавих • Шөнийн цагаар эцэг эх, асран хамгаалагчийн зөвшөөрөлгүй хүүхдийг тээвэрлэх • Цахим орчинд эцэг эхээс нь далдуур хүүхэдтэй харилцах 	<ul style="list-style-type: none"> • Хүүхэд эрсдэлт нөхцөлд байгааг мэдсэн, ажигласан, таамагласан боловч мэдээлэхгүй байх • Хүүхдийг ямар нэгэн хөдөлмөрт хөлслөх. • Ажилтнууд насанд хүрээгүй хүүхдээр өөрийн хүүхдийг асруулах, гэрийн үйлчлэгч хийлгэх, хувийн бизнестээ олон цагаар туслуулах • Оройн 18 цагаас хойших арга хэмжээнд хүүхэд оролцуулах • Эцэг эх, асран хамгаалагчийн зөвшөөрөлгүй хүүхдийг урлаг, спортын үйл ажиллагаанд оролцуулах • Гамшиг осол, уй гашуу тохиолдсон үед хүүхэд, насанд хүрэгчдийн эмзэг байдалд мэдрэмжгүй хандах • Эцэг эх, асран хамгаалагчийн зөвшөөрөлгүйгээр хүүхдийг ганцаарыг нь машинаар авч явах • Ёс заншил, шашны болон зан үйлийн хэлбэртэй үйл ажиллагаанд оролцуулах • Зураг, мэдээллийг хувийн фейсбүүк хуудас ба бусад хувийн нийгмийн сүлжээн дээр тавих • Ажлын байр, хүүхдийн орчинд архи, тамхи мансууруулах эм бодис хэрэглэх
---------------	--	--

Зургаа.Зөрчлийн талаарх мэдээллийг хүлээн авах

6.1.Ажилтан болон бусад хүн бүр хүүхдийн эсрэг аливаа хүчирхийлэл, мөлжлөгийн талаар байгууллагын даргад болон хүүхэд хамгааллын нэгжийн ажилтанд шууд мэдээлэх үүрэгтэй.

6.2.Байгууллага хүүхэд хамгааллын зөрчлийг мэдээлэх, мэдээлэл хүлээн авах, хариу үйлдэл үзүүлэх механизмыг боловсруулан батална (Загвар Хавсралт 4).

6.3.Мэдээллийн эх үүсвэр, төрөл нь:

- ✓ Байгууллагын ажилтан болон бусад хүмүүс Хүүхэд хамгааллын Ёс зүйн дүрмийг зөрчсөн болон зөрчсөн байж болзошгүй үйлдэл, зан үйлийн талаар;

- ✓ Байгууллага дээр болон байгууллагаас явуулж буй үйл ажиллагааны үеэр хүүхэд хүчирхийлэл, дарамт, мөлжлөг, үл хайхрах байдалд өртсөн буюу өртсөн байж болзошгүй сэжгийн талаар;
 - ✓ Орон нутаг, тодорхой газар хүүхдийн аюулгүй байдал алдагдсан, хүүхэд хүчирхийлэл, мөлжлөгт өртсөн болон өртсөн байж болзошгүй талаар;
- 6.4. Мэдээллийг амаар, эсвэл Хавсралт 3-д заасан загвар мэдээлэх хуудсыг бөглөж өгч болно. Хүүхдийн эрх ашгийн төлөө нууцаар мэдээлэл өгч болно.
- 6.5. Мэдээлэгчийн аюулгүй байдлыг эрхэмлэнэ. Мэдээлэгчид өс хонзон санах, аюулгүй байдалд нөлөөлөх аливаа үйлдэл, хандлагыг хүлээн зөвшөөрөхгүй.
- 6.6. Тодорхой шалтгааны улмаас ажилтнууд мэдээллийг байгууллагын хүүхэд хамгааллын нэгжид өгөхөөс гадна орон нутгийн хүүхэд хамгааллын болон хууль цагдаагийн байгууллагад өгч болно.
- Найм. Ажил хэргийн зорилгоор хүүхдийн зургийг авах, хүүхдийн тухай мэдээллийг хэвлэл мэдээлэлд ашиглах журам
- 6.1. Хүүхэд хувийн амьдрал, нууцлалаа хамгаалуулах эрхтэй. Мөн хүүхдийн эмзэг байдал, хүчирхийллийн хохирогч болсон эсвэл эцэг эхийн халамж анхаарлын гадна байдаг зэрэг байдал нь түүнийг дахин хохирогч болгох эрсдэлтэй байдаг тул хүүхдийг хэвлэл мэдээлэлд ашиглахдаа болгоомжтой хандана.
- 6.2. Хүүхдийн зургийг авах, дүрс бичлэг хийхийн өмнө хүүхэд, хүүхдийн эцэг эх, асран хамгаалагчаас зөвшөөрөл авна. Мөн зургийг хаана, хэрхэн ашиглахыг тайлбарлана.
- 6.3. Хүүхдийг зургийг болон хүүхдийн тухай мэдээллийг хэвлэл мэдээлэлд ашиглахдаа хүүхэд бүрийн нэр төрийг дээдэлнэ.
- 6.4. Хүүхдийн зураг, дүрс бичлэг, DVD нь хүүхдийг хүндэтгэсэн байдалтай байгаа эсэхийг хянана. Хүүхэд тохиромжтой хувцасласан байхад анхаарна.
- 6.5. Тухайн зураг нь тухайн сэдэв, үйл явдлын үнэн зөв төлөөлөл болж байгааг хянана.
- 6.6. Хүүхдийн гудамжинд эсвэл асрамж халамжийн төвд амьдардаг эсвэл эрх нь зөрчигдсөн зэрэг эмзэг, эрсдэлтэй байдлын талаар мэдээлэл хийхдээ хүүхдийг танигдуулахгүй байдлаар зургийг авч, мэдээллийг өгнө.
- 6.7. Компани, хувь хүмүүс хүүхдэд тусламж өгөх зэрэг үйл ажиллагаа нь сайшаалтай боловч тэдний энэ үйл ажиллагааг хэвлэл мэдээллээр сурталчлах явцад хүүхдийн нэр хүнд, хувийн амьдралд халдсан зөрчил гарч болзошгүй тул үүнээс сэргийлж, хүүхдийг танигдахгүйгээр зургийг авч, мэдээллийг өгнө.
- 6.8. Зураг, файл нь хүүхдийн нууцыг хөндсөн эсэхийг сайтар хянан, хувийн нууцыг хамгаалан, үйл ажиллагаандаа зохих хэлбэрээ ашиглах зөвшөөрөл хүснэ.

Долоо. Хориглох зүйлс.

- 7.1. Хүүхдэд ялгаварлан гадуурхах байдлаар хандах, зарим нэг хүүхдийг онцгойлон хайрлаж халамжлах.
- 7.2. Хамт аялан явж буй хүүхдээ дагалдан аялагч насанд хүрэгчийн өрөөнд бүтэн шөнийг өнгөрүүлэхэд хүргэх.
- 7.3. Хүүхдүүдэд согтууруулах ундаа, тамхи, хориотой эм тан санал болгох, доромжлолын хэлбэртэй зан байдалтай эвлэрэх, хүчирхийллийн аливаа хэлбэрийг үйлдэхгүй байх, илэрсэн тохиолдолд мэдээлэх арга хэмжээ авах.
- 7.4. Хүүхдийн фото зураг болон түүх, намтарыг хэвлэхдээ тэдний нэр төрийг хүндэтгэх, эмзэг байдлынх нь тухай онцлон дурдахыг хориглоно.

Орон нутгийн өмчийн газрын даргын
2024 оны 08 дугаар сарын 20-ны өдрийн 150
дугаар тушаалын хоёрдугаар хавсралт



ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ЗӨРЧЛИЙН ТАЛААР МЭДЭЭЛЭХ ХУУДАС

Хэрвээ хүүхдэд ямар нэгэн аюул учирсан талаар мэдэж байгаа бол та доорхи хүснэгтийг бөглөнө үү?

1. Таны мэдээлэл

Нэр: _____

Хаана ямар ажил эрхэлдэг: _____

Тухайн хүүхэдтэй ямар холбоотой вэ: _____

Холбоо барих хаяг, утас: _____

2. Хүүхдийн мэдээлэл

Хүүхдийн нэр: _____

Хүүхдийн хүйс, нас _____

Хүүхдийн гэрийн хаяг: _____

Хүүхдийн асран хамгаалагчийн нэр: _____

1. Хэргийн сэжгийн тухай, аль болох тодорхой бэлгийн бие махбодийн, сэтгэл санааны, хүчирхийлэл, шийтгэл, мөлжлөг, үл хайхрах байдал

2. Сэжиглэгдэж буй үйлдлийн болсон он сар өдөр цаг _____

Сэжиглэгдэж буй үйлдэл хаана болсон бэ? _____

Тус үйлдлийг үйлдсэн сэжигтний нэр _____

Нэмэлт мэдээлэл _____